

## **БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮЧИНГИЙН ГЭМТ ХЭРЭГ**

**Охид, эмэгтэйчүүдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг 30 хувиар өссөн.**

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой зарим тоо мэдээллээс дурдвал, цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилд 947<sup>i</sup> буюу ойролцоогоор өдөрт 1 бэлгийн хүчирхийлэл бүртгэгдэж шалгагдсан. Хохирогчдын 80% орчим нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд, 46.8% нь 8-17 насны охид байгаа бөгөөд насанд хүрээгүй хохирогчдын 87<sup>ii</sup> хувь нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид байна. 2017 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчингийн гэмт хэргийн тоо 30 хувиар нэмэгдсэн<sup>iii</sup>. Гэвч энэ тоо мэдээ нь бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг бүхэлд нь илэрхийлж буй тоо мэдээ биш байх магадлалтай. Ихэнх тохиолдолд хохирогчид хууль хяналтын байгууллагад хандахгүй өнгөрөөдөг, хандсан ч хэрэгсэхгүй болох, өргөдлөө татаж авах, гомдолгүй, тохиролцсон гэх зэргээр асуудал орхигддог. Үүнд:

- 1. Насанд хүрээгүй, бага насны хүүхэд ялангуяа охидын эсрэг хүчингийн гэмт хэрэг үүнд ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэгт өртөж буй бага насны хүүхэд, ялангуяа охидын эрхийг хамгаалах эрх зүйн орчин дутмаг байна.**

Ураг төрлийн болон таньдаг хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо “тохиролцоод” хүүхэд хохироод үлддэг асуудал байсаар байгаа нь хохирогчийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байгааг УЕПГ-ын 2019 оны судалгааны үр дүнгээр мэдээлэгдсэн<sup>iv</sup>. Харин ЦБ-д шалгагдсан хэргүүдийн 2 хэргийн 1 нь буюу 45.2% нь л шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг. Зөвхөн сүүлийн 2 сарын хугацаанд гэхэд бага насны хүүхэд хүчиндсэн 6 тохиолдол, хүчингийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан тохиолдлууд дараалан гарлаа.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тоо мэдээгээр “бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн улмаас тус хүрээлэнгээр шинжилгээ хийлгэгчдийн 45.6% буюу 881 нь 0-19 хүртэлх насны хүүхдүүд<sup>v</sup>, 108 хүүхдийн тусламжийн утсанд 2014 онд 46, 2015 онд 131, 2016 онд 169, 2017 оны эхний 5 сарын байдлаар 75 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн дуудлага<sup>vi</sup> бүртгэгджээ”. Энэ бүхэн нь насанд хүрээгүй хүн бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгаа харуулж байгаа юм. Энэ бол зөвхөн бидэнд мэдэгдэж байгаа тоо мэдээлэл бөгөөд хэрэгсэхгүй болсон, буцсан, нуугдмал, тусламж авч чадахгүй байгаа гэмт хэргийн гаралт, хохирогчийг мэдэх, тооцох аргагүй юм.

Хүчиндэх гэмт хэрэг жил бүр 30% орчмоор өсөж (2016-290, 2017-376, 2018-516), насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болох явдал нэмэгдэж, олон нийтийг түгшээж байгаа ч Засгийн газраас энэ гэмт хэрэгтэй тэмцэх бодит, үр дүнтэй, тогтвортой ажлыг хийгээгүй, хоорондоо уялдаа холбоогүй цөөн хэдэн ажлыг байгууллагууд өөрсдийн нөөц болон ОУ-ын доноруудын дэмжлэгээр хийж байгаа ч бодит үр дүнгүй хэвээр байна.

- 2. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн шүүхээр хэргээ шийдүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах зэрэг эрхүүд зөрчигдөж байна.**

“Хүчингийн хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ тодорхойгүй, салангид, очсон газар бүртээ хувиасаа мөнгө төлж үйлчилгээ авдаг нь хүндрэл учруулдаг<sup>viii</sup>”. Тухайлбал: “5 настай хүчингийн хэргийн хохирогч охин шинжилгээний төлбөрт өгөх 10,000 төгрөг байхгүйгээс үзлэгт орж чадахгүй байсан тухай нийгмийн сүлжээгээр хурдацтай тархаж иргэд энэ тухай бага зэргийн ойлгоцтой болж хүчтэй эсэргүүцсэн<sup>viii</sup>. Үүний дараа ХЗДХЯ-наас 0-18 насны хохирогчийг төлбөрөөс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн боловч 18 дээш насны хохирогчид төлбөр төлөх, эсвэл амьдарлын боломжгүйгээ заавал оршин суугаа газраасаа тодорхойлолт авахаар<sup>ix</sup> зохицуулсан нь хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах үндсэн зарчимтай зөрчилдөж байна.

### **3. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин дутмаг байна.**

**ЭХ-ийн нэмэлт өөрчлөлтийн уршгаар 14-16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 2018 оны 10 сарын байдлаар өмнөх оноос 70%-аар өссөн<sup>x</sup> байна.** 2015 оны Эрүүгийн хуулийн 12.5 зүйлд<sup>xi</sup> Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол 450,000-5,400,000 төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл **зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.** ЭХ-нд албан ёсоор бэлгийн харьцаанд орохыг зөвшөөрөх насыг дурдаагүй, ял шийтгэл нь өмнөх хуулийн ижил зохицуулалтаас хэт бууруулсан (торгуулийн доод хэмжээг 22 дахин<sup>xii</sup>, дээд хэмжээг 5 дахин<sup>xiii</sup>). Мөн өмнөх зохицуулалтаар хүчингийн гэмт хэрэгт хүндрүүлэх шалтгаанаар тооцдог байсан хохирогчийг жирэмсэн болгосон, бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь хүүхдийн бэлгийн эрх чөлөөг хамгаалахад ухралт хийсэн гэж үзэж байна. *Тухайлбал Өмнөговь аймгийн шүүхээс 2018 оны 01 дүгээр сард “26 настай А нь 14 настай Ц-г арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдсээр байж бэлгийн харьцаанд орж, хохирогчийг жирэмсэн болгосон, 5 сартай үр зулбасан” гэх үндэслэлээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар 8 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан нь хохирогчид учруулсан хор уршигт тохирсон ял шийтгэл болж чадахгүй байгаад иргэд маш их дургүйцлээ илэрхийлсэн. Иргэний хуулийн 15-р зүйлд зааснаар иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар 18 наснаас эхэлдэг бөгөөд насанд хүрээгүй буюу 14-18 нас хүртэлх иргэн эрх зүйн бүрэн бус чадамжтай байна. Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр хийх тухай хуулийн зохицуулалтын агуулгаас харахад 14 настай хүүхэд бие бялдрын хөгжлийн хувьд 16 эсхүл түүнээс дээш настай байх боломжтой буюу харагдах байдлаар бусдыг төөрөгдөлд оруулахаар байсан ч эрх зүйн чадамжийн хувьд бэлгийн харьцааны талаар хүсэл зориггоо бүрэн илэрхийлэх чадамжгүй байна<sup>xiv</sup>. Гэмт этгээдүүд өсвөр насны, бэлгийн бойжилт явагдаж байгаа насны онцлогтой нь холбоотойгоор хүүхдийг хуурч мэхлэх, төөрөгдөлд оруулах, ятгах зэргээр хүчингийн гэмт хэргийн зорилгоо “багахан” өртгөөр гүйцэлдүүлэх боломжтой зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.*

2015 оны Эрүүгийн хуульд заасан “**Бэлгийн дарамт учруулах**” гэмт хэргийг **2017 оны хуулиар хүчингүй болгон**, ялангуяа энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг хүчингүй болгосон нь ухралт<sup>xv</sup> болсон билээ.

Шинэчилсэн Эрүүгийн хуулийн 12.2 дугаар зүйлд “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах” гэмт хэргийн шинжийг оновчтой бус байдлаар заажээ. “Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харилцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол...” гэж заасан нь бусад нөхцөлд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасныг гэмт хэрэгт тооцохгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, бэлгийн харилцаанд орохгүйгээр хүнийг айлган сүрдүүлж, хүч хэрэглэхээр заналхийлж эсвэл хуурч мэхлэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол хэрхэн зүйлчлэх нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, **хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн (үйлдлийн) дунд зай үлдээд зарим бэлгийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийсэн гэмт хэрэгтэнд ял завших боломж бий**<sup>xvi</sup> болж байна.

#### **4. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх үйлчилгээ хангалтгүй.**

Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээ байхгүй. Бүх байгууллагаар өөрөө явж үйлчилгээ авах болдог нь эдийн засаг, цаг хугацаа, сэтгэл санааны хувьд давхар хохирлыг учруулдаг. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдод учирсан хор хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон нөхөн сэргээх зардлыг тооцож олгодгүйгээс зөвхөн эрүүл мэндийг нөхөн сэргээхэд зарцуулсан хохирлыг зарцуулсан баримтад тулгуурлан олгох хэлбэрээр шүүх шийдэж байна. Хохирогч өөрөө өөрийнхөө төлөө эхлээд төлөх ёстой болдог нь шууд ар гэрийн эдийн засгийн байдлаас хамааралтай байдаг. Эцэг эх, эсвэл насанд хүрсэн хохирогч төлбөрийн чадваргүй байх тохиолдолд үйлчилгээ тус бүрт өөрийн төлбөрийн чадваргүйг нотолж, төрөөс үнэгүй үйлчилгээ авах боломжийг нээхээр зохицуулсан байдаг. Харамсалтай нь энэ нь хувь хүний нууц, ирээдүйтэй нь холбоотой асуудал байдаг тул хохирогчид барагтай бол ханддаггүй.

Мөн мэргэшсэн төрийн байгууллагын ажилтаны чадамж байхгүй байна. Үүнд, нийгмийн ажилтанууд “энэ охин өөрөө дуртай байсан”, “зайлуул энэ залуу энэ явдалтай охиноос болж ял авлаа” гэх мэт ярьж байгаа нь анхан шатны үйлчилгээний ажилтны хандлага нь мэргэжлийн ёс зүйтэй нийцэхгүй байна. Мэргэшсэн буюу сэтгэцийн гэмтэлд суурилсан (trauma-informed) сэтгэл засалын үйлчилгээ байхгүй, нийгэм-сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх шаардлагатай ч Монгол Улсад мэргэшсэн, туршлагатай мэргэжилтэн дутмаг. Одоогийн мэргэжилтэнүүд trauma-informed system/care талаар ойлголцогүй байна. Тиймээс сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ, тогтолцоог нэвтрүүлж чадахгүй байна. Уг сэтгэцийн гэмтэлд суурилсан тогтолцоо гэдэгт боловсрол, эрүүл мэнд ба хууль гэх мэт багтана.

Бүх шатны үйлчилгээ үзүүлэгчид хохирогч буруутгах хандлагатай, үүнд цагдаа, багш, өмгөөлөгч, эмч багтана. Сэтгэцийн гэмтэл (trauma), хохирол, даван туулагч (survivor) гэх ойлголтуудаа мэдэхгүй бөгөөд эрх мэдлээ урвуулан ашиглан (misuse of power) даван туулагч, хохирогчийг буруутгах хандлага давамгайл хэвээр байна.

**Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоход авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмж**

**1. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:**

- 2015 оны шинэчилсэн Эрүүгийн хуулийн 12.5-т заалтыг өөрчлөн, Хүүхдийн эрхийн конвенци, Монгол Улсын Иргэний хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуульд нийцүүлэх, ялын бодлогыг эргэн харах
- Эрүүгийн хуульд “Бэлгийн дарамт учруулах” гэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцож сэргээх;
- Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх стандарт батлах (мөрдөгчдийг мэргэшүүлэх, хэргийг дуустал нэг мөрдөгчөөр шалгуулах, нэг хэргийн насанд хүрээгүй хохирогч, холбогдогчийг хэрхэн байцаах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахдаа хохирогч хүүхдийн сэтгэл зүйн эмзэг байдлыг аль болох сэдрээхгүй байцаах, хяналт тавьж буй прокурорыг солихгүй байх, насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг бүрийг нарийн шалгаж, шүүхээр шуурхай шийдвэрлэх, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, гэмт этгээдтэй тааралдахгүй байх нөхцөл бүрдүүлэх г.м асуудлыг зохицуулсан байх);

**2. Гэмт хэргийн хохирогчийг нөхөн сэргээх чиглэлээр:**

- Хүчиндэх гэмт хэргийн материаллаг бус хохирлыг тооцдог болон сэтгэл засал, нөхөн сэргээх эмчилгээний зардлыг буруутай этгээдээс гаргуулдаг эрх зүйн механизмыг бий болгох;
- Бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэл зүйд учирсан гэмтлийг тогтоох, сэтгэл санааны хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг батлах, хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн тодорхой зохицуулалт, механизмыг бүрдүүлэх;
- Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг сэтгэл санааны давхар дарамтад оруулахаас сэргийлэх үүднээс хохирогчтой ажиллах арга, тусламж үйлчилгээний зөв дараалал, жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, хохирогчийн эрх, хүчирхийллийн шинж тэмдгүүдийг таних зэрэг асуудлаар эмч, багш зэрэг мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын модуль боловсруулж, тасралтгүй зохион байгуулах.<sup>xviiixviii</sup>

**3. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн шүүхээр хэргээ шийдүүлэх явцад хувийн нууцтай байх, хамгаалагдах зэрэг эрхийг хамгаалах чиглэлээр:**

- Шүүх шинжилгээний байгууллагад хандаж буй бэлгийн хүчирхийллийн бүх насны хохирогчдыг үнэ төлбөргүй шинжилгээнд хамруулж байх, тоо мэдээ гаргах аргачлалыг сайжруулах, боловсронгуй болгох, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад статистик мэдээллийг нээлттэй болгох, шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах;

**4. Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх талаар:**

- Хохирогч буруугах хандлага хийгээд бэлгийн хүчирхийллийг таслан зогсоход олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдлэг, мэдээлэл түгээх

ажиллагааны бүхий л үйд явцад хүүхдийн (охид, хөвгүүд) оролцоог бүхий л түвшинд ханган албан болон албан бус аргаар орон даяар нэвтрүүлэх.

- Охид хөвгүүдийн бэлгийн боловсролыг нэмэгдүүлэх

ЕБС-ийн охидын үзлэг нэрээр охидын нэр хүнд, аюулгүй байдалд бүдүүлгээр халдаж байгааг халах.

---

<sup>i</sup> ЦБ-ын гэмт хэргийн статистик мэдээ

<sup>ii</sup> Мөн тэнд

<sup>iii</sup> Мөн тэнд

<sup>iv</sup> УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судлах хүрээлэн, Бага насны хүүхдийн эсрэг чиглэсэн бэлгийн хүчирхийллийн суурь судалгаа, 2019 он,

<sup>v</sup> ЭМЯ, ГС, ХТЭТ. “Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх” судалгааны тайлан. УБ., 2018. 10-р хуудас.

<sup>vi</sup> Хөгжлийн академи ТББ. “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан. УБ., 2017. 1-р хуудас.

<sup>vii</sup> <https://www.legalinfo.mn/annex/details/7807?lawid=12614> Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам

<sup>viii</sup> <https://dnn.mn/%D1%85%D2%AF%D1%87%D0%B8%D1%80%D1%85%D0%B8%D0%B9%D0%BB%D1%8D%D0%BB%D0%B4-%D3%A9%D1%80%D1%82%D1%81%D3%A9%D0%BD-%D1%82%D0%B0%D0%B2%D0%B0%D0%BD-%D0%BD%D0%B0%D1%81%D1%82%D0%B0%D0%B9-%D0%BE%D1%85%D0%B8%D0%BD%D1%8B%D0%B3-%D1%85%D0%B0%D0%BC%D0%B3%D0%B0%D0%B0%D0%BB%D0%B0%D0%BB%D1%82%D0%B0%D0%B4-%D0%B0%D0%B2%D0%BB%D0%B0%D0%B0/>

<sup>ix</sup> <https://www.legalinfo.mn/additional/details/3247?lawid=12614>, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал, 2017.10.31, Дугаар а/263, а/406, 321

<sup>x</sup> Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, галтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, судлагааны тайлан, 2019 он, ХСИС-ын Эрдэм шинжилгээний хүрээлэн, ХТЭТ, МОНЭС

<sup>xi</sup> <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634> 12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

<sup>xii</sup> ЭХ-ийн 122 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх, .... хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>xiii</sup> 2015 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192,000 төг (2015 оны байдлаар 9,792,000-28,800,000 төг)

<sup>xiv</sup> /Иргэний хууль, 2002 он, 16-17 дугаар зүйл/

<sup>xv</sup> Мөн тэнд

<sup>xvi</sup> Мөн тэнд